Ёс зүйн хорооны 2025 оны 12 дугаар
сарын 01-ний өдрийн 09 дүгээр
тогтоолын нэгдүгээр хавсралт

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

2026.01.04

№	Үзүүлэлт	Шалгуур үзүүлэлт		Авбал зохих оноо	Оноо[1]	Хувийн жин[2]
1	2	3		4	5	6
1	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт[3] (ҮХХ)	Үйл ажиллагааны төлөвлөгөөг шалгуур үзүүлэлттэй нийцүүлэн баталсан эсэх[4]		1	0,5	5
2		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээ хийсэн эсэх [5]		1	1	10
3		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байдал	Ёс зүйн сургалтыг 2-оос доошгүй	0,5	0,5	5
			Соён, гэгээрүүлэх нөлөөллийн ажил зохион байгуулсан байдал[7]	0,5	0,5	5
			Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргасан байдал[8]	0,5	0,5	5
			Ёс зүйн зөрчлийн хариуцлагын бүртгэлийнмаягт бөглөсөн байдал[9]	0,5	0,5	5
Хэсгийн оноо				**4**	**3,5**	**35**
4	Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал (ЁЗМ)	Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг үндэслэн шийдвэр гаргасан эсэх [10] *(гарсан дүгнэлтийн хувийн жингээр тооцох бөгөөд гомдол ирээгүй бол 1 оноо)*		1	0,5	5
5		Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, зөрчлийн шийдвэрлэлтийг цахим хуудсанд байршуулсан байдал[11]		1	1	10
6		Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн байдал[12]		1	1	10
Хэсгийн оноо				**3**	**2,5**	**25**

7	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа (ЁЗДХ)	Дэд хорооны бүрэлдэхүүн хөдөлгөөнийг бүртгэсэн байдал[13]	1	1	10
8		Төрийн албан хаагчаас ирүүлсэн гомдол, мэдээллийг шийдвэрлэсэн байдал [14] *(Гомдол ирээгүй бол 1 оноо авна, нийт ирүүлсэн өргөдөл, гомдлын хувийн жингээр тооцно)*	1	1	10
9		Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд систем дэх дүгнэлт, шийдвэрийг бүртгэж, тайлагнасан байдал [15]	1	1	10
	Хэсгийн оноо		**3**	**3**	**30**
	Үнэлгээний нийт оноо, хувь		**10**	**9**	**90**

-oOo-

Ёс зүйн хорооны 2025 оны 12 дугаар
сарын 01-ний өдрийн 09 дүгээр тогтоолын
гуравдугаар хавсралт

БАЙГУУЛЛАГЫН 2025 ОНЫ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН "ТАЙЛАНГИЙН МАЯГТ"

НЭГ. Товч танилцуулга
Төрийн албан хаагчийн ёс зүйн гомдол, мэдээллийг хянан шийдвэрлэх хүрээнд 2025 оны жилийн эцсийн байдлаар аймгийн хэмжээнд нийт 207 байгууллагын ёс зүйн дэд хороонд ирсэн 14 гомдол мэдээлэл бүртгэгдэж, шалган шийдвэрлэсэн байна. Ёс зүйн зөрчилд хүлээлгэсэн хариуцлага ёс зүйн дэд хороодын дүгнэлтээр 6 гомдол, мэдээлэлд ёс зүйн зөрчил тогтоогдож томилох эрх бүхий албан тушаалтан 4 буюу 67 хувьд нь ёс зүйн хариуцлага хүлээлгэж, 2 зөрчилд томилох эрх бүхий албан тушаалтан шийдвэр гаргаагүй байна. 8 гомдол мэдээллийг шалгаж ёс зүйн зөрчил дутагдал гаргаагүй гэж дүгнэсэн байна. Ёс зүйн хорооны 2024 оны 13 дугаар тогтоолоор "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журам"-аар ёс зүйн мэдээллийн цахим сангийн бүрдлийн жагсаалт, Төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар гаргасан гомдол, мэдээлэл, түүний шийдвэрлэлтийн бүртгэлийн маягтын дагуу аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний 26 агентлаг, 17 сумын төр, төсвийн байгууллага, Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот газруудаас мэдээ тайланг татан авч нэгтгэн журмын хэрэгжилтийг ханган ажиллалаа.
ХОЁР. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар
2.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт
Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 30 жилийн ойн хүрээнд Төрийн албаны зөвлөл, Ёс зүйн хороо, Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлөөс Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо, Ёс зүй, дэгийн байнгын хороо, Төвийн бүсийн зөвлөл, Дархан-Уул, Сэлэнгэ, Төв аймгийн ЗДТГ хамтран төвийн бүсийн 450 төрийн албан хаагчдын төлөөлөл оролцуулан зохион байгуулсан зөвлөгөөнд аймаг, сумын Засаг даргын Тамгын газрын ёс зүйн дэд хорооны дарга, гишүүдийг хамруулан "Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийн хэрэглээ" хэлэлцүүлэгт хамтран оролцлоо. Аймгийн албан ёсны цахим хуудас selenge.gov.mn, Сэлэнгэ аймаг ЗДТГ фейсбүүк хаягаар дамжуулан Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр 2024-2030", Монгол Улсын Ёс зүйн хорооны 2025 оны "Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт шинжилгээ үнэлгээний шалгуур үзүүлэлт батлах тухай" 04 дүгээр тогтоол, Ёс зүйн дэд хорооны ажиллах журам, "Ёс

зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргах, шалган шийдвэрлэх талаар авах арга хэмжээний тухай" 07 дугаар тогтоолуудыг байршуулан олон нийтэд түгээсэн. Мөн төрийн албан хаагчдад зориулсан ёс зүйн талаар сургалт нөлөөллийн ажлуудыг шат дараатайгаа зохион байгуулан ажиллаж байна.

Хүний эрхийн комисс, Сэлэнгэ аймгийн Үйлдвэрчний эвлэлийн холбоо, Аймгийн Засан даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтэстэй хамтран сумын төрийн албан хаагч, иргэдийн хүний эрхийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, урьдчилан сэргийлэх чадавхыг бий болгох, төрийн албан хаагч үйл ажиллагаандаа хүний эрхэд суурилсан хандлага, арга зүйг төлөвшүүлэн хэрэгжүүлэх зорилгоор "Хүний эрхийн үндсэн ойлголт ба Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн зохицуулалт", "Төрийн албан хаагчийн ёс зүй", "Хөдөлмөрлөх эрх" сэдвээр сургалтыг 7 сум, 4 байгууллагад сургалт зохион байгуулж нийт 320 албан хаагчийг хамруулсан.

2.2.Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал:

Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх зорилгоор Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, орон нутгийн төрийн байгууллага, албан хаагчдын ёс зүй, манлайллыг нэмэгдүүлэхээр "Төрийн албаны шинэтгэл-Сэлэнгэ аймагт" аяныг өрнүүлсэн.

Аянд аймгийн Засаг даргын Тамгын газар, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний газар, хэлтэс, албад, 17 сум, 6 тосгоны төр, төсвийн байгууллагууд, төрийн албан хаагчид хамрагдаж, байгууллагын болон төрийн албан хаагчдын үйл ажиллагаа, хууль тогтоомжийг сурталчлах, таниулах, төрийн албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, ёс зүй, харилцаа, хандлагыг сайжруулах, төрийн байгууллага, албан хаагчдын болон салбарын уялдаа холбоог хангаж ажиллах чиглэлээр арга хэмжээнүүд зохион байгууллаа.

Удирдлагын академи, Хүний эрхийн үндэсний комиссоос хамтран зохион байгуулсан "Ёс зүй, хүний эрх" сэдэвт 16 цагийн багц сургалтад аймгийн Засаг даргын Тамгын газраас 4 албан хаагч хамрагдаж Төрийн албаны ёс зүй, хүний эрхийн үзэл баримтлал, хүний эрхэд суурилсан төрийн байгууллагын үйл ажиллагаа, хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан албан хаагчдад тавигдах шаардлага, хяналт-шинжилгээ, үнэлгээний цикл дэх ёс зүйн зарчим, хяналт-шинжилгээ, үнэлгээнд ёс зүй, хүний эрхийн хэх хэмжээг баримтлан ажилладаг сайн туршлага, хүний нөөцийг бүрдүүлэх, чадахуйн зарчмын хэрэгжилт, байгууллагын үнэлгээнд анхаарах асуудал сэдэвт хичээлүүдээр тус тус шинэ мэдлэг нэмэгдүүлсний зэрэгцээгээр, ёс зүйн эрсдэлийн үнэлгээний арга зүй, байгууллагын үнэлгээнд ёс зүйн хариуцлагын үзүүлэлт, ёс зүй, хүний эрхийн зөрчлийн шалтгаан, үр дагавар, төрийн байгууллага дахь ёс зүй, хүний эрхийн тулгамдаж буй асуудал, сорилт, шийдэл, ёс зүй, хүний эрхийн зарчимд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээний сорил, шийдэл сэдвийн хүрээнд мэдлэг мэдээллээ бататгасан.

2.3. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа:

Монгол Улсын ёс зүйн хорооноос 2025 оны 10 сарын 17-ноос 30-ны өдрийн хооронд зохион байгуулсан "Төрийн албан дахь ёс зүйн зөрчил: иргэд болон төрийн албан хаагчдын санаа бодлыг тандах тоон болон чанарын судалгаа"-ны ажилд манай аймгийн Засаг даргын Тамгын газар сонгогдож хамтран ажиллалаа.

Дээрх судалгаа нь төрийн албан дахь ёс зүйн зөрчлийн шалтгаан, нөлөөлөх хүчин зүйлийн талаар төрийн албан хаагчид болон иргэдийн санаа бодлыг тандах,

ёс зүйн зөрчлийг бууруулах чиглэлээр урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахад ашиглах арга зүй, аргачлал, зөвлөмж боловсруулах үндсэн зорилготой судалгааны ажилд мэдээлэл цуглуулах ажлыг байгууллагын хэмжээнд зохион байгууллаа.

Төрийн албан хаагчдаас авах судалгаа-1 Судалгааны зорилго, ач холбогдлыг тайлбарласан танилцуулгыг нийт албан хаагчдад хүргэж, QR код, богино холбоосыг өөрийн байгууллагын дотоод цахим хаяг, дотоод сүлжээ, чат группээр түгээсэн. Нийт 63 албан хаагчийг хамруулсан.

Иргэдээс авах судалгаа-2 Иргэдээс мэдээлэл цуглуулах ажлыг Хавсралт 2 QR код бүхий хуудсыг хэвлэж иргэдийн үйлчлүүлэх хэсэгт байршуулах, үйлчилгээ үзүүлж буй албан хаагчдаар дамжуулан хүргэж 62 иргэнийг хамруулахаас нийт 66 иргэнээр бөглүүлэн судалгааны хугацаанд багтаан амжилттай зохион байгуулж хамтран хамтран ажиллалаа.

Мөн байгууллагын Ёс зүйн дэд хорооноос 2025 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн мэдээллийн цаг арга хэмжээнд "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр 2024-2030"-ийн товч танилцуулгыг дэд хорооны гишүүн Б.Болортуяа 38 албан хаагчид танилцуулж, ёс зүйтэй төрийн албыг төлөвшүүлэхэд байгууллага хамт олноороо манлайлан хамтран ажиллах уриалга гаргасан.

Архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгийн хүрээнд аймгийн Засаг даргын 2025 оны А/524 дугаар захирамжийн хүрээнд аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 26 агентлаг, 17 сум, 6 тосгоны Засаг даргын Тамгын газар, төр, төсвийн нийт байгууллагад төрийн байгууллагын ажлын зохион байгуулалтыг үнэлэх аргачлалын дагуу үзлэгийг зохион байгуулсан. Үзлэгийн хүрээнд аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний харьяа агентлагууд, сумдын төр, төсвийн байгууллагуудын Ёс зүйн дэд хороодын үйл ажиллагаанд үнэлгээ дүгнэлт өгч, дэд хорооны ажиллах журам, гомдол мэдээллийг хянан шийдвэрлэх ажиллагаа болон Төрийн албан хаагчдын ёс зүйн тухай хуулийн мэдлэг мэдээллийг дээшлүүлэхэд чиглэсэн үр дүнтэй ажил арга хэмжээг зохион байгуулж ажиллах талаар зөвлөгөө, чиглэл өгч ажилласан.

Мөн Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын Ерөнхий боловсролын сургуулиас ирүүлсэн албан хүсэлтийн дагуу сум орон нутгийн төрийн албан хаагчдын ёс зүйн тухай хуулийн мэдлэг мэдээллийг дээшлүүлэх, соён гэгээрүүлэхэд чиглэгдсэн сургалт зохион байгуулахад шаардагдах зардлыг аймгийн Засаг даргын захирамжаар нэг сая төгрөгийг шийдвэрлэн дэмжлэг үзүүлж, хамтран ажилласан.

2025 оны жилийн байдлаар аймгийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчидтай холбоотой ёс зүйн талаарх гомдол мэдээлэл бүртгэгдээгүй, ёс зүйн зөрчил дутагдалгүй ажилласан.

Боловсролын салбарын нийт 79 нэгж байгууллагын удирдах ажилтан болон Ёс зүйн дэд хорооны гишүүдийг чадваржуулах болон ажлын хариуцлага, сахилга бат, байгууллагын соёлыг төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлэх, соён гэгээрүүлэх зорилгоор газрын Ёс зүйн дэд хорооны дарга, Боловсролын хяналтын улсын ахлах байцаагч Ц.Цогт-эрдэнэ "Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль" сэдвээр цахим сургалт сурталчилгааг зохион байгуулсан.

Сэлэнгэ аймаг Сант сумын Засаг даргын Тамгын газрын даргын 2024 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн А/08 тоот тушаалаар “Ёс зүйн дэд хороо”-г шинэчлэн байгуулагдаж, 7 арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Монгол Улсын Их Хурлын 2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 27 дугаар тогтоол Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд нөлөөллийн ажлыг идэвхжүүлэх, төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг сурталчилж, ёс зүйтэй орчин бүрдүүлэх, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, ажлыг идэвхтэй зохион байгуулан ажилласан.

Засаг даргын Тамгын газрын “Журмын нөхөд”, “Сант сумын ёс зүйн дэд хороо” цахим хуудсаар төрийн албан хаагчийн ёс зүйн эрсдэлээс урьдчилан арга хэмжээ, ёс зүйн нийтлэг шаардлага, төрийн албаны үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага MNS 7068:2025 стандартаа хэрэгжүүлэн ажиллахыг уриалж холбогдох хууль журам, батлагдсан стандартаа даган мөрдөж ажиллах нь аливаа ёс зүйн эрсдэл, зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлэх талаар соён гэгээрүүлэх сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг үе шаттайгаар зохион байгуулсан.

Ёс зүйн дэд хорооноос санаачлан Улаанбатар хотод Хувь хүний хөгжлийн мэргэжлийн сургагч багш А.Амаржаргал багштай хамтран “Багаар ажиллах ур чадвар” сургалтыг зохион байгуулсан.

“Дэлхийн ёс зүйн өдөр” өглөө бүр бие биедээ талархал илэрхийлж, өдөр бүр хамт олондоо эерэг өдрийг бэлэглэн эерэг хандлагатай, бие биедээ тэвчээртэй, хүлээцтэй, хүндэтгэлтэй хандаж эерэг хандлагыг өөрсдийн үг, үйлдлээрээ хамт олондоо түгээцгээж ТАЛАРХЛЫН БУЛАН, кофетой яриа, АХА тэмцээн зохион байгууллаа.

Гарсан үр дүн, ололт амжилт, бэрхшээл:

“Төрийн албаны шинэтгэл Сэлэнгэ аймаг”-т аяны хүрээнд Монгол Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын дэргэдэх “Бизнес Академи”, Юнайтед менежмент консалтинг” ХХК-тай хамтран манлайлал, менежментийн ур чадварыг сайжруулах “Harvard Manage Mentor” цогц хөтөлбөрийг Сэлэнгэ аймгийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдыг чадавхжуулах зорилгоор 2025 оны 06 дугаар сард 2 дахь шатны сургалтыг зохион байгуулж, Байгууллагын соёл, Төрийн албан хаагчийн зөөлөн ур чадвар, Өөрчлөлтийн менежмент сэдвүүдээр сургалтыг зохион байгуулж, “Байгууллагын соёлыг тодорхойлох үнэлгээ”-нд нийт албан хаагчдыг хамруулсан.

Байгууллагын хөгжил нь удирдлага болоод ажилтнуудын хөгжилтэй шууд хамааралтай байдаг тул хүний нөөцийн бодлогын хүрээнд ажилтнуудаа бүх талаар таньж мэдэн, түүн дээр тулгуурлан хөгжүүлэлтээ хийх нь нэн тэргүүний асуудал

байна. Аймгийн Засаг даргын Тамгын газар нь энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлснээр улсын хэмжээнд төрийн байгууллагуудаас анх удаа төрийн байгууллагын албан хаагчдын ёс зүй, ур чадварын түвшин, байгууллагын соёлын талаарх нэгдсэн судалгааг гаргалаа.

Төрийн албан хаагчдын ёс зүй ур чадварын нэгдсэн үнэлгээг хувь хүн өөрийн зан төлөвт гаргах хандлага болон бусдын зан төлөвт гаргах хандлагын түвшинд тодорхойлсон. Бусдын зан төлөвт гарах хандлагыг үнэлснээр бусдын үйлдэл, зан

чанарыг хүлээн зөвшөөрөх чадварыг харж, хувь хүн өөрт гаргах хандлагыг тодорхойлсноор тухайн хүний өөрийн ёс зүйгүй үйлдэл, зан авирыг хүлээн зөвшөөрөх чадварыг харах боломжтой болсон.

Мөн байгууллагын соёлын нэгдсэн судалгааг гаргаснаар байгууллагад төлөвшсөн үнэт зүйлс, ажилтнуудын хандлага, зан төлөв, ажиллах орчны сэтгэл ханамж, хамт олны уур амьсгал, манлайлал, харилцаа, шийдвэр гаргалт зэрэг соёлын чухал хэмжигдэхүүнүүдийг тодорхойлж, тэдгээрийн өнөөгийн түвшинг үнэлэн, ажилтнуудын хандлагад суурилсан мэдээлэл дээр үндэслэн байгууллагын соёлыг бэхжүүлэх, хөгжүүлэх арга замыг тодорхойлж хэрэгжүүлэхэд чухал алхам болсон.

Санал:

1.Ёс зүйн хорооны 2024 оны “Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” 10 дугаар тогтоолын 4-д заасан гомдол мэдээлэл шалган шийдвэрлэх харьяалалд Сумын Тамгын газрын дарга, томилох эрх бүхий албан тушаалтан, ёс зүйн дэд хорооны дарга, гишүүдийн ёс зүйн асуудлаар ирсэн гомдол мэдээллийг аймгийн Засаг даргын Тамгын газрын ёс зүйн дэд хороо шалгахаар байгааг өөрчлөн аймгийн Засаг даргын дэргэдэх ёс зүйн хороог удирдлагын багаас сонгон байгуулж шалган шийдвэрлэдэг болох,

2.Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 13.4.1.гишүүнээр ажилласны төлөө урамшуулал авах, Ёс зүйн дэд хорооны ажиллах журмын 3.8 5 болон 7 хүний бүрэлдэхүүнтэй Дэд хорооны нарийн бичгийн даргад хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 50 хувьтай тэнцэх хэмжээний урамшууллыг сар бүр, дарга, гишүүдэд хурал болон бусад арга хэмжээнд оролцсон ирц, идэвх оролцоог харгалзан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцож, улиралд нэг удаа урамшуулал олгоно. 3 хүний бүрэлдэхүүнтэй Дэд хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүнд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэх хэмжээний урамшууллыг улирал тутамд олгоно гэсэн заалт орон нутагт хэрэгжихгүй байгаад анхаарах, шийдвэрлүүлэх шаардлагатай байна.

Шалгах хэсэг:

- “Ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлт”-ийн дагуу үнэлгээ хийсэн эсэх.
- Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн баталсан үйл ажиллагааны төлөвлөгөө хавсаргасан эсэх.
- Байгууллагын 2025 оны ЁС зүйн дэд хорооны хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг маягтын дагуу бүрэн тайлагнасан эсэх.

БАТАЛГААЖУУЛАЛТ:

Томилох эрх бүхий албан тушаалтан

Засаг даргын
Тамгын газрын дарга Ө.СУВДАА

ЁС зүйн дэд хорооны дарга

Төрийн захиргааны удирдлагын
хэлтсийн дарга Д.ХИШИГБАТ

Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга

Автотээврийн хяналтын
улсын байцаагч Г.НАНСАЛМАА

2026 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр

БАТЛАВ.
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА Ө.СУВДАА

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ
2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Арга хэмжээ	Төсөв	Зорилт	Хүрэх түвшин	Хугацаа	Хариуцаж хамтран зохион байгуулах нэгж /албан тушаалтан/
Нэг. Үндсэн үйл ажиллагаа, зохион байгуулалтын хүрээнд.						
Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, ёс зүйн хорооны тогтоолын хүрээнд Ёс зүйнд эд хороонд ирүүлсэн гомдлыг хэлэлцэн шийдвэрлэх, тайлан мэдээ гаргах						
1.1	Ёс зүйн дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулж хэрэгжилтийг ханган ажиллах	0	2025 оны төлөвлөгөөг боловсруулан батлах	Ёс зүйн дэд хорооны төлөвлөгөө бүрэн хэрэгжсэн байна.	I улиралд	Ёс зүйн дэд хороо
1.2	Төрийн албан хаагчийн ёс зүйтэй холбоотой ирүүлсэн гомдлыг хүлээн авч, хэлэлцэн шийдвэрлэх	0	Гомдлын баримтыг үндэслэн үнэн зөвөөр шийдвэрлэх, иргэний болон ажилтны хууль ёсны эрх ашгийг хамгаалах	Ёс зүйн зөрчлийг хууль, тогтоомжийн дагуу үнэн зөв шийдвэрлэсэн байна.	I-IV улиралд	Ёс зүйн дэд хороо
1.3	Ёс зүйн дэд хорооны тайланг тогтоосон хугацаанд Ёс зүйн хороонд хүргүүлэх	0	Тогтоосон хугацаанд тайланг баталгаажуулан хүргүүлэх	Гомдол мэдээллийн тоо буурсан, мэдээ тайлан хугацаанд нь үнэн зөв хүргүүлсэн байна.	I-IV улиралд	Ёс зүйн дэд хороо
1.4	"Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналт" дэд системд мэдээллийг тухай бүр бүртгэн оруулах	0	Зөрчлийн талаарх гомдол мэдээлэл, төлөвлөгөө түүний хэрэгжилтийг тухай бүр дэд системд бүртгэн баталгаажуулах	Өөрийн байгууллагын хүрээн дэх ёс зүйн дэд хороог чадавхжуулах, үйл ажиллагааг хэвийн	Жилдээ	Ёс зүйн дэд хороо

				явуулах нөхцөл бүрдсэн байна.		
1.5	2025 оны жилийн эцсийн үйл ажиллагааны тайланг танилцуулах	0	Ёс зүйн дэд хорооны хийсэн ажил арга хэмжээг АЗДТГ-ын хамт олонд хүргэх	2025 онд зохион байгуулсан ажил, арга хэмжээг хамт олонд тайлагнасан байна.	IV улиралд	Ёс зүйн дэд хороо, Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэс
1.6	Ёс зүйгээр хамт олноо манлайлан ажилласан нэг албан хаагчийг шалгаруулж, урамшуулах	100,000	Шинэлэг санааг дэмжин ажиллах	Албан хаагчдыг дэмжин урамшуулж ажилласан байна.	IV улиралд	Ёс зүйн дэд хороо
1.7	Аймгийн Засаг даргын Тамгын газрын ёс зүйн дэд хорооны 1 гишүүнийг хамт олны саналаар сонгох ажлыг зохион байгуулах	0	Ёс зүйн дэд хорооны хэвийн үйл ажиллагааг хангах	Ёс зүйн дэд хорооны гишүүдийн тоо бүрдсэн байна.	I улиралд	Ёс зүйн дэд хороо
Хоёр. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн /2024-2030/ хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд						
2.1	Байгууллагын албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцож үнэлэх	0	Ёс зүйн хорооноос баталсан аргачлалын дагуу зохион байгуулах	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэл буурсан байна.	II улиралд	Ёс зүйн дэд хорооны гишүүн Т.Энхтунгалаг
2.2	Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд контент бэлтгэн олон нийтэд түгээх	0	Хамт олны сэтгэл зүйд эергээр нөлөөлөх	Ёс зүйн зөрчлөөс урьдчилсан сэргийлсэн байна.	I-IV улиралд	Ёс зүйн дэд хороо. Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэс
2.3	Шинээр ажилд томилогдсон албан хаагчдад төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм, журам, байгууллагын хөдөлмөрийн дотоод журмыг тус тус танилцуулж цаашид мөрдөж ажиллах талаар хариуцлагын баталгаа гаргуулах ажлыг зохион байгуулах	0	Ёс зүйн дүрэм, журам, байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын талаарх хууль эрх зүйн мэдлэгээр хангах	Шинээр ажилд томилогдсон албан хаагчдаас хариуцлагын баталгааг гаргуулан авч, ёс зүйтэй алдаа дутагдал гаргахгүй ажилласан байна.	I-IV улиралд	Ёс зүйн дэд хороо, аймгийн Төрийн албаны зөвлөл
2.4	Төрийн албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулах	0	Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд 4 удаа сургалт нөлөөллийн арга	Төрийн албан хаагчийн ёс зүйнтэй холбоотой өргөдөл гомдлын тоо буурсан байна.	I-IV улиралд	Ёс зүйн дэд хороо, аймгийн Төрийн албаны зөвлөл

			хэмжээг зохион байгуулах			
2.5	Жил бүрийн 10 дугаар сарын 18-ны өдрийг дэлхий даяар "Ёс зүйн" өдрийг тэмдэглэн арга хэмжээ зохион байгуулах	400,000	"Хамгийн ёс зүйтэй хувцасладаг төрийн албан хаагч"-ийг сонгон шалгаруулах "2025 онд ажлын цагаар тасалж, хоцроогүй төрийн албан хаагч"-ийг сонгон шалгаруулах "Хамгийн сайн мэндлэх хүндлэх ёсыг хэрэгжүүлдэг төрийн албан хаагч"- ийг сонгон шалгаруулах	Шилдэг ёс зүйтэй албан хаагчдыг сонгон шалгаруулж нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулсан байна.	IV улиралд	Ёс зүйн дэд хорооны гишүүн Т.Энхтунгалаг
2.6	Төрийн үйлчилгээний албан хаагчдын хөдөлмөрийн гэрээнд ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр заалт тусгах	0	Шинээр боловсруулах	Шинээр оруулах заалтын саналыг боловсруулан хөдөлмөрийн гэрээнд тусгасан байна.	II улиралд	Ёс зүйн дэд хороо
2.7	Төрийн албаны ёс зүй, сахилга, дэг журам, хариуцлагыг чангатгах талаар дээд шатны байгууллагаас ирүүлсэн шийдвэрийг хэрэгжилтийг тайлагнах	0	Хууль тогтоомж тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажиллах	Тогтоосон хугацаанд тайлагнасан байна.	Тухай бүр	Ёс зүйн дэд хороо
2.8	Байгууллагын албан хаагчдыг нэгдсэн загварын ажлын үнэмлэх, нэрийн хуудастай болгох	0	Шинээр боловсруулж, хэвлүүлэх	Нийт ажилчдыг ажлын үнэмлэх, нэрийн хуудастай болгосон байна.	IV улиралд	Ёс зүйн дэд хорооны гишүүн Т.Энхтунгалаг
2.9	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны тайлан болон холбогдох бусад баримт бичгийг архивын стандартын дагуу үдэж архивд хүлээлгэн өгөх	0	Архивд баримтыг хүлээлгэн өгөх	Архивд баримтыг хүлээлгэн өгсөн байна.	IV улиралд	Ёс зүйн дэд хороо
	Нийт дүн	500,000				

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ
2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2025.12.05

№	Арга хэмжээ	Хүрэх түвшин	Биелэлт	Биелэлтийн хувь
1.1	Ёс зүйн дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулж хэрэгжилтийг ханган ажиллах	Ёс зүйн дэд хорооны төлөвлөгөө бүрэн хэрэгжсэн байна.	Байгууллагын ёс зүйн дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны 17 заалт бүхий төлөвлөгөөг боловсруулан батлуулж төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажилласан. Мөн зөвлөлийн тухайн онд хийж хэрэгжүүлсэн дэлгэрэнгүй бичмэл тайланг холбогдох мэдээ мэдээллийн хамт хавсаргав.	100
1.2	Төрийн албан хаагчийн ёс зүйтэй холбоотой ирүүлсэн гомдлыг хүлээн авч, хэлэлцэн шийдвэрлэх	Ёс зүйн зөрчлийг хууль, тогтоомжийн дагуу үнэн зөв шийдвэрлэсэн байна.	Тайлант хугацаанд Төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар бичгээр гаргасан нийт 8 гомдол, өргөдлийг хүлээн авч, 2 өргөдлийг харьяалалтын дагуу шилжүүлсэн. Мөн аймгийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх Ёс зүйн дэд хорооны хуралдааныг 12 удаа зохион байгуулж, 5 гомдол мэдээллийг бүрэн шийдвэрлэж албан ёсны дүгнэлтийг гомдол гаргагч болон томилох эрх бүхий албан тушаалтанд хуулийн хугацаанд нь хүргүүлж, “Ёс зүйн хороо”-ны цахим бүртгэл мэдээллийн санд бүртгэж баталгаажуулсан. Түүнчлэн гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй 1 гомдлыг холбогдох хуулийн дагуу аймгийн Цагдаагийн газарт шилжүүлсэн. Тухайн тайлант онд ёс зүйн дэд хорооноос гаргасан дүгнэлтүүдтэй холбоотой гомдол санал ирээгүй байна.	100
1.3	Ёс зүйн дэд хорооны тайланг тогтоосон хугацаанд Ёс зүйн хороонд хүргүүлэх	Мэдээ тайлан хугацаанд нь үнэн зөв хүргүүлсэн байна.	Ёс зүйн дэд хорооноос зохион байгуулсан ажил, арга хэмжээ, өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн талаарх тайланг хагас, бүтэн жилээр баримт материалын хамт нэгтгэн гаргаж, зохих журмын дагуу заасан хугацаанд нь тайлагнасан. Мөн ёс зүйн зөрчилтэй холбоотой соён гэгээрүүлэх сургалт, мэдээ мэдээллийн ажил арга хэмжээг байгууллагын дотоод нэгжийн албан хаагчид болон сумдын Засаг даргын Тамгын газар, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудын нийт албан хаагчдад баталсан хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу холбогдох хууль журам хүрээнд мэдээ мэдээллийг өгч ажиллалаа.	100
1.4	“Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналт” дэд системд мэдээллийг тухай бүр бүртгэн оруулах	Өөрийн байгууллагын хүрээн дэх ёс зүйн дэд хороог чадавхжуулах, үйл ажиллагааг хэвийн	Байгууллагын Ёс зүйн дэд хорооны дарга, нарийн бичиг, гишүүдийн холбогдох мэдээ мэдээллийг hrm.csc.gov.mn цахим системийн бүрэлдэхүүн модул хэсэгт баталсан хүснэгтийн дагуу бүрэн гүйцэд бүртгэж баталгаажуулсан. Энэ оны жилийн эцсийн байдлаар ирсэн нийт 6 гомдол, өргөдөл мэдээллийг тус цахим системийн дэд системд бүрэн гүйцэд бүртгэж тогтоосон хугацаанд баталгаажуулж ажиллалаа.	100

		явуулах нөхцөл бүрдсэн байна.		
1.5	2025 оны жилийн эцсийн үйл ажиллагааны тайланг танилцуулах	2025 онд зохион байгуулсан ажил, арга хэмжээг хамт олонд тайлагнасан байна.	Ёс зүйн дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны тайланг нэгтгэн аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулсан. Мөн тухай тайлант онд зохин байгуулсан арга хэмжээний талаарх товч мэдээ мэдээллийн талаарх танилцуулга илтгэлийг байгууллагын “Мэдээллийн цаг” арга хэмжээний хөтөлбөрт тусгуулан танилцуулга мэдээлэл хийсэн.	100
1.6	Ёс зүйгээр хамт олноо манлайлан ажилласан нэг албан хаагчийг шалгаруулж, урамшуулах	Албан хаагчдыг дэмжин урамшуулж ажилласан байна.	“Ёс зүйтэй төрийн албан хаагч”-ийг шалгаруулах шалгуур үзүүлэлтийг дэд хорооны зүгээс боловсруулан байгууллагын удирдлагаар батлуулж хэрэгжүүлэн ажилласан. Энэхүү ажлын хүрээнд нийт албан хаагчдаа ёс зүйгээр манлайлан ажилласан нэг албан хаагчийг хамт олны санал болон удирдлагын багийн саналыг үндэслэн, дэд хорооны гишүүдийн саналаар оны эцэст шалгаруулж урамшуулсан.	100
1.7	Аймгийн Засаг даргын Тамгын газрын ёс зүйн дэд хорооны 1 гишүүнийг хамт олны саналаар сонгох ажлыг зохион байгуулах	Ёс зүйн дэд хорооны гишүүдийн тоо бүрдсэн байна.	Ёс зүйн дэд хорооны гишүүнээр сонгогдон ажиллаж байсан С.Чойсүрэн өөр албан тушаалд шилжин томилогдсон. Орон гарсан нэг гишүүнийг нөхөн томилохоор хамт олны 2025 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн хурлаар санал авч нийт хуралд оролцсон 38 албан хаагчаас 11 албан хаагчийн саналаар Нийтлэг үйлчилгээний албарын дарга С.Жавзанжамба сонгогдон томилогдсон. Ёс зүйн дэд хороо нь 2025 оны жилийн эцсийн байдлаар 7 хүний бүрэлдэхүүтэй ажиллаж байна. Шинээр сонгогдсон 1 гишүүний мэдээллийг ёс зүйн цахим дэд системд бүртгэл үүсгэн баталгаажуулсан.	100
2.1	Байгууллагын албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцож үнэлэх	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэл буурсан байна.	Сэлэнгэ аймгийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдыг чадавхжуулах зорилгоор нийт 38 албан хаагчдад эхний үе шатны сургалтыг зохион байгуулж, “Ажлын байрны ёс зүй”, “Сэтгэл хөдлөлөө удирдах оюуны чадамж”, “Карьер менежмент” Логик сэтгэлгээ ба төлөвлөлт, “Аз жаргал ба стресс менежмент”, “Цагийн менежмент, хурлын менежмент”, “Инновацыг хэрэгжүүлэх, бүтээлч байдал”, Багаар ажиллах чадвар, хамтарч ажиллах, чадвар, дасан зохицох, “Бусдыг манлайлах”, “Амжилттай хэлцэл хийх”, “Төслийн менежмент”, Процессын сайжруулалт”, “Гүйцэтгэлийн үнэлгээ”, “Төслийн менежмент” зэрэг сэдвүүдийн хүрээнд сургалтыг зохион байгуулж, “Албан хаагчдын ажлын байран дахь ёс зүйн үнэлгээ”, “Менежерийн ур чадварыг тодорхойлох үнэлгээ”-нүүдийг хийсэн. Үнэлгээг үндэслэн “Төрийн албаны шинэтгэл Сэлэнгэ аймаг”-т аяны хүрээнд 2025 оны 06 дугаар сард тус сургалтын 2 дахь шатыг зохион байгуулж, Байгууллагын соёл, Төрийн албан хаагчийн	100

			зөөлөн ур чадвар, Өөрчлөлтийн менежмент сэдвүүдээр сургалтыг зохион байгуулж, “Байгууллагын соёлыг тодорхойлох үнэлгээ”-нд нийт албан хаагчдыг хамруулсан. Байгууллагын хөгжил нь удирдлага болоод ажилтнуудын хөгжилтэй шууд хамааралтай байдаг тул хүний нөөцийн бодлогын хүрээнд ажилтнуудаа бүх талаар таньж мэдэн, түүн дээр тулгуурлан хөгжүүлэлтээ хийх нь нэн тэргүүний асуудал байна. Аймгийн Засаг даргын Тамгын газар нь энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлснээр улсын хэмжээнд төрийн байгууллагуудаас анх удаа төрийн байгууллагын албан хаагчдын ёс зүй, ур чадварын түвшин, байгууллагын соёлын талаарх нэгдсэн судалгааг гарган төрийн албан хаагчдын ёс зүй ур чадварын нэгдсэн үнэлгээг хувь хүн өөрийн зан төлөвт гаргах хандлага болон бусдын зан төлөвт гаргах хандлагын түвшинд тодорхойлсон.	
2.2	Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд контент бэлтгэн олон нийтэд түгээх	Ёс зүйн зөрчлөөс урьдчилсан сэргийлсэн байна.	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 8 дугаар зүйлийн Төрийн албан хаагчид тавигдах төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг шаардлага сэдвээр богино хэмжээний видео Хууль эрх зүйн хэлтэс, аймгийн Байгаль орчны газартай хамтран хийж олон нийтэд түгээж урьдчилан сэргийлэх нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан. 2025 оны жилийн эцсийн байдлаар аймгийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчид ёс зүйн зөрчил дутагдалгүй ажиллалаа.	100
2.3	Шинээр ажилд томилогдсон албан хаагчдад төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм, журам, байгууллагын хөдөлмөрийн дотоод журмыг тус тус танилцуулж цаашид мөрдөж ажиллах талаар хариуцлагын баталгаа гаргуулах ажлыг зохион байгуулах	Шинээр ажилд томилогдсон албан хаагчдаас хариуцлагын баталгааг гаргуулан авч, ёс зүйтэй алдаа дутагдал гаргахгүй ажилласан байна.	2025 онд Төрийн захиргааны удирдлагын хэлтэст-1, Бүс орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтэст-2, Салбарын хяналт зохицуулалтын хэлтэст-1, Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэст-1, Нийгмийн бодлогын хэлтэст-1, Хэвлэл мэдээллийн албанд-2, Нийтлэг үйлчилгээний албанд-3 нийт 11 шинээр томилогдсон албан хаагчид байгууллагын дотоод журам, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг танилцуулан баталгаа гаргуулан авсан.	100
2.4	Төрийн албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулах	Төрийн албан хаагчийн ёс зүйнтэй холбоотой өргөдөл гомдлын тоо буурсан байна.	Байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хорооноос 2025 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн мэдээллийн цаг арга хэмжээнд “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр 2024-2030”-ийн товч танилцуулгыг дэд хорооны гишүүн Б.Болортуяа 38 албан хаагчид танилцуулж, ёс зүйтэй төрийн албыг төлөвшүүлэхэд	100

			байгууллага хамт олноороо манлайлан хамтран ажиллах уриалга гарган ажилласан.	
2.5	Жил бүрийн 10 дугаар сарын 18-ны өдрийг дэлхий даяар "Ёс зүйн" өдрийг тэмдэглэн арга хэмжээ зохион байгуулах	Шилдэг ёс зүйтэй албан хаагчдыг сонгон шалгаруулж нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулсан байна.	Дэлхийн ёс зүйн өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд байгууллагын нийт албан хаагчдад ёс зүйн чиглэлээр сургалт мэдээллийн арга хэмжээ зохион байгуулсан. Мөн ёс зүйн зөрчил түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт сурталчилгаа, мэдээ мэдээлэл агуулга бүхий зурагт хуудас, богино хэмжээний кино контент зэргийг бэлтгэн олон нийтэд сурталчилан ажилласан. Мөн орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагууд болон хамтран ажилладаг телевиз, цахим сайтуудаар холбогдох мэдээ мэдээллийг нийтэд түгээж ажилласан.	100
2.6	Төрийн үйлчилгээний албан хаагчдын хөдөлмөрийн гэрээнд ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр заалт тусгах	Шинээр оруулах заалтын саналыг боловсруулан хөдөлмөрийн гэрээнд тусгасан байна.	Хөдөлмөрийн гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулан ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаарх заалтыг тусгах саналыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс, хүний нөөцийн мэргэжилтэнд зохих журмын дагуу боловсруулан хүргүүлсэн. Холбогдох шийдвэрийг хөдөлмөрийн гэрээнд шинэчлэн тусгахаар боловрсуулалтыг хийж байна.	100
2.7	Төрийн албаны ёс зүй, сахилга, дэг журам, хариуцлагыг чангатгах талаар дээд шатны байгууллагаас ирүүлсэн шийдвэрийг хэрэгжилтийг тайлагнах	Хуулийн хугацаанд тайлагнасан байна.	Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 01 дүгээр албан даалгаврын хүрээнд Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллаж, авлига, албан тушаалын гэмт хэрэг, хүнд суртал, шударга бус байдалтай тууштай тэмцэх, таслан зогсоох, албан тушаал, эрх мэдлээ урвуулан ашиглахгүй байх, төрийн байгууллагын дэргэдэх ёс зүйн дэд хороодын үйл ажиллагааг идэвхжүүлэх үүрэг чиглэлийг бүх шатны дарга нарт даалгасан. Энэхүү албан даалгаврын хүрээнд аймгийн хэмжээнд нийт 207 байгууллагын ёс зүйн дэд хорооны тайлан мэдээг татан авч нэгтгэн хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг тогтоосон хугацаанд нь тайлагнан цахим системд бүртгэн баталгаажуулсан.	100
2.8	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны хүрээнд ажилтан албан хаагчдаас сэтгэл ханамжийн судалгаа, санал авах	2026 оны ажлын төлөвлөгөөнд тусгах санал авч боловсруулах	2026 онд зохион байгуулах ажил арга хэмжээний саналыг нийт албан хаагчдаас авч нэгтгэн аймгийн удирдлагуудад танилцуулан ирэх оны төлөвлөлтөнд тусгаж батлуулан ажилласан. Түүнчлэн ирэх онд хэрэгжүүлэх онцлох ажил арга хэмжээнүүдийг эрэмблэн холбогдох зардлыг шийдвэрлүүлэн төлөвлөгөөг батлуулсан.	100

2.9	Байгууллагын албан хаагчдыг нэгдсэн загварын ажлын үнэмлэх, нэрийн хуудастай болгох	Шинээр боловсруулж, хэвлүүлэх	Байгууллагын нэгжийн дарга нар болон нийт албан хаагчдийг нэг стандарт загварын нэрийн хуудастай болгосон бөгөөд нийт төрийн захиргааны албан хаагчдын ажлын үнэмлэхийн эх загварыг шинэчлэн боловсруулж үнэмлэхжүүлсэн.	100
2.10	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны тайлан болон холбогдох бусад баримт бичгийг архивын стандартын дагуу үдэж архивд хүлээлгэн өгөх	Архивд баримтыг хүлээлгэн өгсөн байна.	2025 оны жилийн эцсийн байдлаарх байгууллагын Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, Төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар гаргасан гомдол, мэдээлэл, түүний шийдвэрлэлтийн талаарх тоон мэдээ, бичмэл тайлан бусад холбогдох материалыг бүрдүүлэн архивын хадгаламжийн нэгж болгон байгууллагын архивт хүлээлгэн өгөхөд бэлэн болсон.	100
Төлөвлөгөөний биелэлтийн хувь				**100**

_____oOo_____

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЁС ЗҮЙН ДЭД ХОРООДЫН
2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2025.12.05 Сүхбаатар сум

НЭГ. ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 7 дугаар зүйлд төрийн албан хаагчийн сахин мөрдөх ёс зүйн нийтлэг хэм хэмжээг, 8 дугаар зүйлд төрийн албан хаагчид тавигдах ёс зүйн нийтлэг шаардлагыг нийтлэг үүрэг болон хориглох үйл ажиллагааг тусгасан. Тухайн хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-т “Хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 8.1, 8.2-т заасныг зөрчсөн тохиолдолд томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан Ёс зүйн хорооны, Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг үндэслэн зөрчлийн шинж байдал, анх буюу давтан үйлдсэнийг нь харгалзан дараах ёс зүйн хариуцлагын аль нэгийг ногдуулна” гэж хуульчилсан.

Төрийн албан хаагчид энэ хуулийн 7.1-т заасан нийтлэг хэм хэмжээг сахин биелүүлэхийн тулд Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйл, Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйл, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн Гуравдугаар бүлэгт заасан хориглолт, хязгаарлалт болон бусад хориглох үйл ажиллагааг тусгаж өгсөн. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 11, 13 дугаар зүйлд Ёс зүйн хороо, төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороо хуулиар харьяалуулсан төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол, мэдээллийг хянан шалгаж, дүгнэлт гаргах бүрэн эрхтэй гэж заасан.

Төрийн албан хаагчийн ёс зүйн гомдол, мэдээллийг хянан шийдвэрлэх хүрээнд 2025 оны жилийн эцсийн байдлаар аймгийн хэмжээнд нийт 207 байгууллагын ёс зүйн дэд хороонд ирсэн 14 гомдол мэдээлэл бүртгэгдэж, шалган шийдвэрлэсэн байна.

Ёс зүйн зөрчилд хүлээлгэсэн хариуцлага ёс зүйн дэд хороодын дүгнэлтээр 6 гомдол, мэдээлэлд ёс зүйн зөрчил тогтоогдож томилох эрх бүхий албан тушаалтан 4 буюу 67 хувьд нь ёс зүйн хариуцлага хүлээлгэж, 2 зөрчилд томилох эрх бүхий албан тушаалтан шийдвэр гаргаагүй байна. 8 гомдол мэдээллийг шалгаж ёс зүйн зөрчил дутагдал гаргаагүй гэж дүгнэсэн байна.

Ёс зүйн хорооны 2024 оны 13 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журам”-аар ёс зүйн мэдээллийн цахим сангийн бүрдлийн жагсаалт, Төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар гаргасан гомдол, мэдээлэл, түүний шийдвэрлэлтийн бүртгэлийн маягтын дагуу аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний 26 агентлаг, 17 сумын төр, төсвийн байгууллага, Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот газруудаас мэдээ тайланг татан авч нэгтгэн журмын хэрэгжилтийг ханган ажиллалаа.

ХОЁР. ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА


Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 30 жилийн ойн хүрээнд Төрийн албаны зөвлөл, Ёс зүйн хороо, Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлөөс Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо, Ёс зүй, дэгийн байнгын хороо, Төвийн бүсийн зөвлөл, Дархан-Уул, Сэлэнгэ, Төв аймгийн ЗДТГ хамтран төвийн бүсийн 450 төрийн албан хаагчдын төлөөлөл оролцуулан зохион байгуулсан зөвлөгөөнд аймаг, сумын Засаг даргын Тамгын газрын ёс зүйн дэд хорооны дарга, гишүүдийг хамруулан “Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийн хэрэглээ” хэлэлцүүлэгт хамтран оролцлоо.



Аймгийн албан ёсны цахим хуудас selenge.gov.mn, Сэлэнгэ аймаг ЗДТГ фейсбүүк хаягаар дамжуулан Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр 2024-2030”, Монгол Улсын Ёс зүйн хорооны 2025 оны “Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт шинжилгээ үнэлгээний шалгуур үзүүлэлт батлах тухай” 04 дүгээр тогтоол, Ёс зүйн дэд хорооны ажиллах журам, “Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргах, шалган шийдвэрлэх талаар авах арга хэмжээний тухай” 07 дугаар тогтоолуудыг байршуулан олон нийтэд түгээсэн. Мөн төрийн албан хаагчдад зориулсан ёс зүйн талаар сургалт нөлөөллийн ажлуудыг шат дараатайгаа зохион байгуулан ажиллаж байна.

Хүний эрхийн комисс, Сэлэнгэ аймгийн Үйлдвэрчний эвлэлийн холбоо, Аймгийн Засан даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтэстэй хамтран сумын төрийн албан хаагч, иргэдийн хүний эрхийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, урьдчилан сэргийлэх чадавхыг бий болгох, төрийн албан хаагч үйл ажиллагаандаа хүний эрхэд суурилсан хандлага, арга зүйг төлөвшүүлэн хэрэгжүүлэх зорилгоор "Хүний эрхийн үндсэн ойлголт ба Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн зохицуулалт", "Төрийн албан хаагчийн ёс зүй", "Хөдөлмөрлөх эрх" сэдвээр сургалтыг 7 сум, 4 байгууллагад сургалт зохион байгуулж нийт 320 албан хаагчийг хамруулсан.





Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх зорилгоор Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, орон нутгийн төрийн байгууллага, албан хаагчдын ёс зүй, манлайллыг нэмэгдүүлэхээр “Төрийн албаны шинэтгэл-Сэлэнгэ аймагт” аяныг өрнүүлсэн.

Аянд аймгийн Засаг даргын Тамгын газар, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний газар, хэлтэс, албад, 17 сум, 6 тосгоны төр, төсвийн байгууллагууд, төрийн албан хаагчид хамрагдаж, байгууллагын болон төрийн албан хаагчдын үйл ажиллагаа, хууль тогтоомжийг сурталчлах, таниулах, төрийн албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, ёс зүй, харилцаа, хандлагыг сайжруулах, төрийн байгууллага, албан хаагчдын болон салбарын уялдаа холбоог хангаж ажиллах чиглэлээр арга хэмжээнүүд зохион байгууллаа.



“Төрийн албаны шинэтгэл Сэлэнгэ аймаг”-т аяны хүрээнд Монгол Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын дэргэдэх “Бизнес Академи”, Юнайтед менежмент консалтинг” ХХК-тай хамтран манлайлал, менежментийн ур чадварыг сайжруулах “Harvard Manage Mentor” цогц хөтөлбөрийг Сэлэнгэ аймгийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдыг чадавхжуулах зорилгоор 2025 оны 06 дугаар сард 2 дахь шатны сургалтыг зохион байгуулж, Байгууллагын соёл, Төрийн албан хаагчийн зөөлөн ур чадвар, Өөрчлөлтийн менежмент сэдвүүдээр сургалтыг зохион байгуулж, “Байгууллагын соёлыг тодорхойлох үнэлгээ”-нд нийт албан хаагчдыг хамруулсан.

Байгууллагын хөгжил нь удирдлага болоод ажилтнуудын хөгжилтэй шууд хамааралтай байдаг тул хүний нөөцийн бодлогын хүрээнд ажилтнуудаа бүх талаар таньж мэдэн, түүн дээр тулгуурлан хөгжүүлэлтээ хийх нь нэн тэргүүний асуудал байна. Аймгийн Засаг даргын Тамгын газар нь энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлснээр улсын хэмжээнд төрийн байгууллагуудаас анх удаа төрийн байгууллагын албан хаагчдын ёс зүй, ур чадварын түвшин, байгууллагын соёлын талаарх нэгдсэн судалгааг гаргалаа.

Төрийн албан хаагчдын ёс зүй ур чадварын нэгдсэн үнэлгээг хувь хүн өөрийн зан төлөвт гаргах хандлага болон бусдын зан төлөвт гаргах хандлагын түвшинд тодорхойлсон. Бусдын зан төлөвт гарах хандлагыг үнэлснээр бусдын үйлдэл, зан чанарыг хүлээн зөвшөөрөх чадварыг харж, хувь хүн өөрт гаргах хандлагыг

тодорхойлсноор тухайн хүний өөрийн ёс зүйгүй үйлдэл, зан авирыг хүлээн зөвшөөрөх чадварыг харах боломжтой болсон.

Мөн байгууллагын соёлын нэгдсэн судалгааг гаргаснаар байгууллагад төлөвшсөн үнэт зүйлс, ажилтнуудын хандлага, зан төлөв, ажиллах орчны сэтгэл ханамж, хамт олны уур амьсгал, манлайлал, харилцаа, шийдвэр гаргалт зэрэг соёлын чухал хэмжигдэхүүнүүдийг тодорхойлж, тэдгээрийн өнөөгийн түвшинг үнэлэн, ажилтнуудын хандлагад суурилсан мэдээлэл дээр үндэслэн байгууллагын соёлыг бэхжүүлэх, хөгжүүлэх арга замыг тодорхойлж хэрэгжүүлэхэд чухал алхам болсон.

Удирдлагын академи, Хүний эрхийн үндэсний комиссоос хамтран зохион байгуулсан “Ёс зүй, хүний эрх” сэдэвт 16 цагийн багц сургалтад аймгийн Засаг даргын Тамгын газраас 4 албан хаагч хамрагдаж Төрийн албаны ёс зүй, хүний эрхийн үзэл баримтлал, хүний эрхэд суурилсан төрийн байгууллагын үйл ажиллагаа, хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан албан хаагчдад тавигдах шаардлага, хяналт-шинжилгээ, үнэлгээний цикл дэх ёс зүйн зарчим, хяналт-шинжилгээ, үнэлгээнд ёс зүй, хүний эрхийн хэх хэмжээг баримтлан ажилладаг сайн туршлага, хүний нөөцийг бүрдүүлэх, чадахуйн зарчмын хэрэгжилт, байгууллагын үнэлгээнд анхаарах асуудал сэдэвт хичээлүүдээр тус тус шинэ мэдлэг нэмэгдүүлсний зэрэгцээгээр, ёс зүйн эрсдэлийн үнэлгээний арга зүй, байгууллагын үнэлгээнд ёс зүйн хариуцлагын үзүүлэлт, ёс зүй, хүний эрхийн зөрчлийн шалтгаан, үр дагавар, төрийн байгууллага дахь ёс зүй, хүний эрхийн тулгамдаж буй асуудал, сорилт, шийдэл, ёс зүй, хүний эрхийн зарчимд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээний сорил, шийдэл сэдвийн хүрээнд мэдлэг мэдээллээ бататгасан.



Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисстой хамтран 2025 оны 05 дугаар сард Түшиг, Цагааннуур, Шаамар, Зүүнбүрэн Сант, Шаамар, Алтанбулаг, сумдад





Хүний эрхийн ойлголт, эрхээ хамгаалуулах, зөрчигдсөн эрхээ сэргээлгэх, Авлигын эсрэг хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулиар сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулсан. Төр төсвийн байгууллагын дарга холбогдох албан хаагчид нийт 214 албан хаагчид хамрагдсан. Төрийн албаны шинэтгэл–Сэлэнгэ аймагт” аян, “Хүүхдийн байгууллага, хөдөлгөөн үүсэж хөгжсөний 100 жилийн ойн” хүрээнд нийгмийн салбарын мэргэжилтнүүдийг чадавхжуулах, салбарын төрийн албан хаагчдын ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэх, зорилгоор Төрийн албан

хаагчийн ёс зүйн тухай хуулиар сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулж 17 сумын Нийгмийн бодлогын мэргэжилтэн, гэр бүлийн нийгмийн ажилтан болон түр хамгаалах байрны нийгмийн ажилтнууд 54 албан хаагчид хамрагдсан.

Мөн Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 8 дугаар зүйлийн Төрийн албан хаагчид тавигдах төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг шаардлага сэдвээр богино хэмжээний видео хийж олон нийтэд түгээсэн.

Засгийн газрын “Иргэд олон нийттэй харилцах 1111 төв”-д ирсэн өргөдөл, гомдлыг ангилан үзэхэд эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа хандлагатай холбоотой гомдол дийлэнх хувийг эзэлж байгааг харгалзан Төрийн албаны зөвлөлийн “Шинэчлэлээр түүчээлсэн салбар зөвлөл” аяны хүрээнд Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/406 дугаар тушаалын хэрэгжилтийг эрчимжүүлж, эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн ёс зүй, харилцаа хандлагыг сайжруулах зорилгоор 2025 оны 06 дугаар сарын 20-ний өдөр эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар, хэсэг, баг, хорооны нийт 85 гишүүдийг хамруулсан чадавхжуулах сургалтыг Эрүүл мэндийн яамтай хамтран зохион байгууллаа. Сургалтын сургагч багшаар Эрүүл мэндийн яамны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хорооны дарга, АУ-ны доктор, дэд профессор Д.Оюунбилэг, Соён гэгээрүүлэх дэд зөвлөлийн дарга, АУ-ны магистр, Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх сургагч багш Ш.Алтанцэцэг нар ажиллалаа.




ГУРАВ. ЁС ЗҮЙН ХОРООДЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА, САНААЧИЛСАН ОНЦЛОХ АЖЛУУД


Аймгийн Засаг даргын Тамгын газар:

Монгол Улсын ёс зүйн хорооноос 2025 оны 10 сарын 17-ноос 30-ны өдрийн хооронд зохион байгуулсан “Төрийн албан дахь ёс зүйн зөрчил: иргэд болон төрийн албан хаагчдын санаа бодлыг тандах тоон болон чанарын судалгаа”-ны ажилд манай аймгийн Засаг даргын Тамгын газар сонгогдож хамтран ажиллалаа.

Дээрх судалгаа нь төрийн албан дахь ёс зүйн зөрчлийн шалтгаан, нөлөөлөх хүчин зүйлийн талаар төрийн албан хаагчид болон иргэдийн санаа бодлыг тандах, ёс зүйн зөрчлийг бууруулах чиглэлээр урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахад ашиглах арга зүй, аргачлал, зөвлөмж боловсруулах үндсэн зорилготой судалгааны ажилд мэдээлэл цуглуулах ажлыг байгууллагын хэмжээнд зохион байгууллаа.



Төрийн албан хаагчдаас авах судалгаа-1 Судалгааны зорилго, ач холбогдлыг тайлбарласан танилцуулгыг нийт албан хаагчдад хүргэж, QR код, богино холбоосыг өөрийн байгууллагын дотоод цахим хаяг, дотоод сүлжээ, чат группээр түгээсэн. Нийт 63 албан хаагчийг хамруулсан.



Иргэдээс авах судалгаа-2 Иргэдээс мэдээлэл цуглуулах ажлыг Хавсралт 2 QR код бүхий хуудсыг хэвлэж иргэдийн үйлчлүүлэх хэсэгт байршуулах, үйлчилгээ үзүүлж буй албан хаагчдаар дамжуулан хүргэж 62 иргэнийг хамруулахаас нийт 66 иргэнээр бөглүүлэн судалгааны хугацаанд багтаан амжилттай зохион байгуулж хамтран хамтран ажиллалаа.

Мөн байгууллагын Ёс зүйн дэд хорооноос 2025 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн мэдээллийн цаг арга хэмжээнд “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр 2024-2030”-ийн товч танилцуулгыг дэд хорооны гишүүн Б.Болортуяа 38 албан хаагчид танилцуулж, ёс зүйтэй төрийн албыг төлөвшүүлэхэд байгууллага хамт олноороо манлайлан хамтран ажиллах уриалга гаргасан.





Архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгийн хүрээнд аймгийн Засаг даргын 2025 оны А/524 дугаар захирамжийн хүрээнд аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 26 агентлаг, 17 сум, 6 тосгоны Засаг даргын Тамгын газар, төр, төсвийн нийт байгууллагад төрийн байгууллагын ажлын зохион байгуулалтыг үнэлэх аргачлалын дагуу үзлэгийг зохион байгуулсан. Үзлэгийн хүрээнд аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний харьяа агентлагууд, сумдын төр, төсвийн байгууллагуудын Ёс зүйн дэд хороодын үйл ажиллагаанд үнэлгээ дүгнэлт өгч, дэд хорооны ажиллах журам, гомдол мэдээллийг хянан шийдвэрлэх ажиллагаа болон Төрийн албан хаагчдын ёс зүйн тухай хуулийн мэдлэг мэдээллийг дээшлүүлэхэд чиглэсэн үр дүнтэй ажил арга хэмжээг зохион байгуулж ажиллах талаар зөвлөгөө, чиглэл өгч ажилласан.

Мөн Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын Ерөнхий боловсролын сургуулиас ирүүлсэн албан хүсэлтийн дагуу сум орон нутгийн төрийн албан хаагчдын ёс зүйн тухай хуулийн мэдлэг мэдээллийг дээшлүүлэх, соён гэгээрүүлэхэд чиглэгдсэн сургалт зохион байгуулахад шаардагдах зардлыг аймгийн Засаг даргын захирамжаар нэг сая төгрөгийг шийдвэрлэн дэмжлэг үзүүлж, хамтран ажилласан.

2025 оны жилийн байдлаар аймгийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчидтай холбоотой ёс зүйн талаарх гомдол мэдээлэл бүртгэгдээгүй, ёс зүйн зөрчил дутагдалгүй ажилласан.

Боловсролын газар:

Боловсролын салбарын нийт 79 нэгж байгууллагын удирдах ажилтан болон Ёс зүйн дэд хорооны гишүүдийг чадваржуулах болон ажлын хариуцлага, сахилга

бат, байгууллагын соёлыг төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлэх, соён гэгээрүүлэх зорилгоор газрын Ёс зүйн дэд хорооны дарга, Боловсролын хяналтын улсын ахлах байцаагч Ц.Цогт-эрдэнэ “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль” сэдвээр цахим сургалт сурталчилгааг зохион байгуулсан.

Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар:

Шинээр томилогдсон 9 албан хаагчид ажлын байран дээр чадавхжуулах **“Миний ажлын нэг өдөр”** арга хэмжээг зохион байгуулж, Алтанбулаг, Сүхбаатар сумын 2 мэргэжилтнийг оролцуулсан видео контент бэлтгэн хууль тогтоомжийг сурталчлах ажлыг зохион байгуулсан. Мөн байгууллагын 25 албан хаагчид “Сэтгэл зүйн эрүүл мэнд” сэдэвт ёс зүйн сургалтыг зохион байгуулсан.

Татварын газар:

Аймгийн Татварын газрын ёс зүйн дэд хорооноос санаачлан байгууллагадаа **“ХАРИЛЦАН ХҮНДЭТГЭЭ”** аяныг 2025 оны 04 сарын 01-ний өдрөөс 10-ны өдрүүдэд хамт олны эв нэгдлийг бэхжүүлэх, эерэг нөлөөлөл бий болгох зорилгоор “Би чамаас-Чи надаас” сэдэвт урам өгөх хүндэтгэлийн захидлыг албан хаагчид бие биедээ бичихийг уриалан зохион байгуулж ажилласан. Мөн “Ажилтны ёс зүй, харилцаа хандлага”-ын талаар нийт 15 асуулга боловсруулан судалгаа авч, үр дүнг нэгтгэн Газрын даргад танилцуулсан. Судалгаанд нийт 47 ажилтан, албан хаагчдаас 33 албан хаагч хамрагдсан байна.

Сэлэнгэ аймгийн Алтанбулаг суманд 7 төр төсвийн байгууллага байдаг бөгөөд байгууллага бүр ёс зүйн дэд хороог байгуулан дотооддоо төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.

Алтанбулаг сум

Алтанбулаг сумын Засаг даргын Тамгын газрын дэргэдэх Ёс зүйн дэд хороо нь төр, төсвийн байгууллагын албан хаагчид болон ёс зүйн дэд хорооны гишүүдийг






чадавхжуулах зорилгоор **Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, “Хөдөлмөрийн тухай хууль, “Ёс зүйн дэд хорооны ажиллах журам”, “Төрийн албан хаагчийн харилцаа хандлага-ёс зүй”, “Байгууллагын соёл, ажлын байрны эмх цэгц”, “Оффисын ажилтай хүнд тохиолдож болох 10 төрлийн өвчнөөс урьдчилан сэргийлэх”** сэдэвт сургалтыг 150 албан хаагчид зохион байгуулсан. Албан хаагчдын ёс зүй харилцаа хандлагатай холбоотой нууц санал асуулгыг 23 албан хаагчаас авч хангалтгүй

үнэлэгдсэн албан хаагчдад харилцаа хандлагаа сайжруулах талаар ганцаарчлан зөвлөгөө өгч ажилласан.



Монгол улсын ёс зүйн дэд хорооноос зарласан **“Хүндэлье-Энэрье” аянд нэгдэж “Хүндлэлээр эхлүүлсэн өдөр амжилтаар бялхдаг”**, **“Миний сэтгэлийн илгээмж”** арга хэмжээг 19 албан хаагчдын хамруулан зохион байгуулсан. Арга хэмжээг төрийн албан хаагчийн харилцаа, хамтын ажиллагааны эерэг уур амьсгалыг бүрдүүлэх, дэмжих, урам өгөх, талархах, хамт олны халуун дулаан мэдрэмжийг өдөөх, мэдлэгээ хуваалцах зорилгоор зохион байгуулсан. Байгууллагын ёс зүйг эрхэмлэсэн соёлын орчныг төлөвшүүлэх зорилгоор 97 төрийн албан хаагчаас судалгаа авч дүгнэлт гаргалаа.





Баруунбүрэн сум

Баруунбүрэн сумын Засаг даргын Тамгын газрын ёс зүйн дэд хороо нь хамт олны уур амьсгалыг дээшлүүлэх, бие биедээ урмын сайхан үгийг харамгүй илгээх, аливаа зүйлд нэг сэтгэлээр хамтран ажиллах чадварыг дээшлүүлэх зорилгоор **“Хайр түгээе”** аян, соёлын өвийг сурталчлан таниулах ажлын хүрээнд “**Монгол бахархал**” арга хэмжээ, “Мэдлэгтэй мэргэжилтнүүд” уралдааныг баримт бичиг боловсруулах, цахим хэрэглээний ур чадварыг сайжруулах зорилгоор зохион байгуулсан. Мөн “Хувь хүний харилцааны ур чадвар”, “Жендерийн эрх тэгш байдал” сургалт, **“Ёстой зүйтэй төрийн албан хаагч”** эссэ бичлэгийн уралдааныг нийт албан хаагчдын дунд зохион байгуулсан.





Төрийн албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, байгууллагын ёс зүйн соёлыг сайжруулах ажлын хүрээнд **“Ёс зүй гэж юу вэ”** сэдэвт сургалтыг зохион байгуулсан. Мөн шинээр ажилд томилогдсон 5 албан хаагчдад ёс зүйн дэд хорооны гишүүд байгууллагын дотоод журам, төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм, харилцаа хандлага, ажил хэрэгч харилцааны талаар сургалт, мэдээлэл хийж ажилласан.

Баянгол сум


Баянгол сумын Засаг даргын Тамгын газрын ёс зүйн дэд хороо нь сумын Засаг даргын Тамгын газрын даргын 2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн А/11 тоот тушаалаар шинэчлэгдэн байгуулагдаж, 2025 онд хийж хэрэгжүүлэх 8 арга хэмжээ төлөвлөж, дэд хорооны даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажилласан. Монгол улсын Төрийн албаны зөвлөлөөс бүсчлэн зохион байгуулсан Ёс зүйн дэд хорооны гишүүдийн сургалтад байгууллагын ёс зүйн дэд хорооны гишүүд бүрэн хамрагдсан. Монгол улсын Засгийн газрын 2024 оны 109 дүгээр тогтоолоор батлагдсан **“Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчдыг ёс зүйн хэм хэмжээ”-**





ний эрх зүйн баримтыг ёс зүйн дэд хорооноос нийт 22 албан хаагчдад танилцуулж, сургалт зохион байгууллаа. “Оймандах ёс зүйн академи”-тай хамтран төрийн захиргааны болон үйлчилгээний 7 байгууллагын нийт 107 албан хаагчдад **“Байгууллагын соёл ба ажилтнуудын ёс зүй”, “Харилцаа, хандлагыг урлах нь”, “Хувь хүний ёс зүйн төлөвшил”** сэдвээр мэдлэг олгох, чадавхжуулах сургалтыг зохион байгуулж, байгууллага тус бүрд гэрчилгээжүүлсэн.

Мөн Засаг даргын тамгын газар, Ерөнхий боловсролын сургууль, 1-р цэцэрлэгийн ёс зүйн дэд хорооны нийт 10 гишүүдийг чадавхжуулах сургалтыг тусгайлан зохион байгуулж мэдлэг олгосон.



Баянгол сумын ЗДТГ-ын ёс зүйн дэд хороо, сумын хөдөлмөр халамж үйлчилгээний мэргэжилтэнтэй хамтран "Ахмад ажилтан зөвлөж байна" уулзалтыг ЗДТГ-ын албан хаагчдын дунд зохион байгуулж, туршлага хуваалцан, ажил хэрэгч санал санаачлага гарган, хэрэгжүүлж ажиллахаар шийдвэрлэсэн.

Ерөө сум

Ерөө сумын Засаг даргын Тамгын газрын дэргэдэх Ёс зүйн дэд хороог 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн А/03 тоот захирамжаар шинэчлэн байгуулан төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд 5 зорилт 12 чиглэлийн ажлын төлөвлөгөөг батлуулан ажиллалаа.

Ёс зүйтэй иргэдээр төрийн албаны хүний нөөцийг бүрдүүлэх тогтолцоог хөгжүүлэх зорилтын хүрээнд: Төрийн албаны зөвлөлийн 2025 оны “Зөвшөөрөл олгох тухай” 70, 208, 338 дугаар тогтоолын дагуу төрийн захиргааны удирдах болон гүйцэтгэх 11 албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн батлан мөрдүүлж байна. Мөн төрийн үйлчилгээний удирдах албан тушаалтан Эрүүл мэндийн төвийн дарга, Соёлын төвийн даргын албан тушаалын тодорхойлолтыг батлан мөрдүүлсэн.



Ёс зүй сахилга хариуцлагаар үлгэрлэсэн төрийн байгууллагын соёлыг хэвшүүлэх зорилтын хүрээнд: “Төрийн албаны шинэтгэл- Сэлэнгэ аймагт” аяны хүрээнд ЗДТГ-ын албан хаагчид Авлигын эсрэг хууль болон Төрийн албанд ажиллахын давуу тал сэдвээр контент бэлтгэн цахим сайтад байршуулан иргэд олон нийтэд төрийн албаны давуу талыг сурталчлан ажиллалаа.



Төрийн албан хаагч ёс зүйтэй ажиллахад дэмжлэг үзүүлэх сургалт, нөлөөллийн ажлыг идэвхжүүлэх зорилтын хүрээнд:

7 хоног бүрийн даваа гаригт Засаг даргын Тамгын газрын өглөөний сонсгол мэдээллийн цагаар албан хаагчид салбарын чиглэлийн хуулиар илтгэл бэлтгэн бусдадаа мэдээлэл хүргэн ажиллаа.





“Эртэч, ёс зүйтэй ажилтан сарын аяныг” өрнүүлэн “Хамгийн эртэч албан хаагч”, “Хамгийн хариуцлагатай албан хаагч”-ийг тодруулан урамшуулан ажилласан.

Төрийн албан хаагчийн ёс зүйтэй ажиллах орчин , нөхцөлийг бүрдүүлж, дэмжих арга хэрэгслийг өргөжүүлэх ажлын хүрээнд : Засаг даргын Тамгын газрын өглөөний сонсгол мэдээллийн цаг дээр “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль”-ийн танилцуулгыг нийт 22, “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай

хууль”, “Ёс зүйн дэд хорооны ажиллах журам”-ын эмхэтгэл бэлтгэн 21 албан хаагчдад хүргэсэн.

Соён гэгээрүүлэх ажлын хүрээнд “**ДАРААГИЙН ХҮНДЭЭ ЮУ ӨГӨХ ВЭ”** чалленжийг Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын дунд зохион байгууллаа.

Зүүнбүрэн сум

Монгол Улсын Ёс зүйн хорооны 2024 оны “Журам батлах тухай” 05 дугаар тогтоолоор батлагдсан “Ёс зүйн дэд хорооны ажиллах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.4 дэх заалтыг үндэслэн Зүүнбүрэн сумын Засаг даргын Тамгын газрын даргын 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн А/16 тоот тушаалаар Ёс зүйн дэд хороог шинэчлэн баталсан.



Ёс зүйн дэд хорооноос байгууллагын албан хаагчдад Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Ёс зүйн хэм хэмжээ, Хөдөлмөрийн дотоод журам, “Амьдралын үнэ цэнэ, утга учир” сургалтыг зохион байгуулж, “Миний хамтрагчийн хамгийн сайхан 3 чанар” санал асуулга явуулж, судалгааны




дүнг нэгтгэн дүгнэж албан хаагч бүрийн сайн сайхан чанаруудыг сурталчлан багаар ажиллах, хамт олны халуун дулаан уур амьсгал бүрдүүлсэн үр дүнтэй арга хэмжээ болсон.

Ёс зүйн дэд хорооноос төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчид ажлын чиг баримжаа олгох, байгууллагын соёл, үйл ажиллагааг танилцуулах арга хэмжээг зохион байгуулсан. Байгууллагын албан хаагчдад “Авилга, ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх”, “Жендерт суурилсан хүчирхийллийн хэлбэр” сэдвээр сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулсан. Мөн Дэлхийн ёс зүйн өдрийн хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 109 дүгээр тогтоолоор батлагдсан Төрийн захиргааны болон үйлчилгээний



албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, Төрийн албаны зөвлөлийн 2025 оны 06 дугаар сарын 25-ны 318 тоот тогтоолоор баталсан Төрийн албаны үйл ажиллагаанд тавих ерөнхий шаардлага, стандартын хэрэгжилтийг хангах тухай, MNS



7068:2025 стандартын тухай сургалт зохион байгууллаа.

Мандал сум

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу авлига, албан тушаалын гэмт хэрэг, хүнд суртал, шударга бус байдалтай тууштай тэмцэн, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх ,ёс зүйн асуудлаар гаргасан гомдол мэдээллийг хянан шалгаж дүгнэлт гаргах зорилго бүхий “Ёс зүйн дэд хороо” сумын ЗДТГ-ын даргын 2025 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/51 дүгээр тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр батлагдаж үйл ажиллагаа зохион байгуулсан. Мөн Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын системээ тогтмол хөтлөн төлөвлөгөө, тайланг оруулж байна. Ёс зүйн зөв дадал хэвшүүлэх зорилгоор сар бүрийн мэдээллийн самбарт 12 удаагийн зөвлөмж, санамж нийтэлсэн.

Дэлхийн Зөн Монгол Олон Улсын байгууллагын санхүүжилтээр төрийн албан хаагчдад "ХҮНИЙ ХӨГЖИЛ-БАЙГУУЛЛАГЫН ХӨГЖИЛ" сэдвээр нэг өдрийн сургалт зохион байгуулагдаж 42 албан хаагч хамрагдлаа.







Хувь хүн, гэр бүл, байгууллага болон нийгмийн сэтгэл зүйн хэрэгцээг хангах замаар тэдний сэтгэл санааны эрүүл мэндийг дэмжих, хүн хоорондын харилцаа, зан үйлийг эергээр өөрчлөх, стресс, сэтгэл гутрал, сөрөг мэдрэмжийг даван туулах чадварыг нэмэгдүүлэх, өөрийгөө танин мэдэх, хөгжүүлэх боломжийг бүрдүүлэх, улмаар эрүүл, бүтээлч, аз жаргалтай ажиллах орчныг бий болгоход чиглэсэн сэтгэл зүйн сургалтыг Сэтгэл судлаач, эмч Р.Энхтүвшинтэй хамтран албан хаагчдад сургалт зохион байгуулсан.

Мөн байгууллагын “Мэдээллийн цаг” үйл ажиллагаанд төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэгжилт болон гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулсан.

“Хүндэлье Энэрье” арга хэмжээний үеэр“Сэтгэлийн бэлэг” үйл ажиллагааг зохион байгуулан хамт олны уур амьсгалыг сэргээсэн.

Монгол бахархалын өдрийг тохиолдуулан“ Төрийн албан хаагчдын зөвлөгөөн”-ийг зохион байгуулан “Эртэч Монгол ”ТББ-тай “Ажлын стрессийг дарах стресс менежмент” сургалтыг мөн зохи он байгуулан төрийн өмчийн 44 байгууллагын төлөөлөл 390 албан хаагчийг хамруулаа.



Тайлант хугацаанд Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын системд бүртгэгдсэн гомдол мэдээлэл байхгүй, ёс зүйн дэд хороо нь төрийн албан хаагчдын ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэх, ил тод, хариуцлагатай төрийн үйлчилгээг сайжруулах чиглэлээр тогтвортой ажиллаж, бодит үр дүнд хүрч ажилласан.

Сант сум

Сэлэнгэ аймаг Сант сумын Засаг даргын Тамгын газрын даргын 2024 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн А/08 тоот тушаалаар “Ёс зүйн дэд хороо”-г шинэчлэн байгуулагдаж, 7 арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Монгол Улсын Их Хурлын 2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 27 дугаар тогтоол Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд нөлөөллийн ажлыг идэвхжүүлэх, төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг сурталчилж, ёс зүйтэй орчин бүрдүүлэх, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, ажлыг идэвхтэй зохион байгуулан ажилласан.



Засаг даргын Тамгын газрын “Журмын нөхөд”, “Сант сумын ёс зүйн дэд хороо” цахим хуудсаар төрийн албан хаагчийн ёс зүйн эрсдэлээс урьдчилан арга хэмжээ,




ёс зүйн нийтлэг шаардлага, төрийн албаны үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага MNS 7068:2025 стандартаа хэрэгжүүлэн ажиллахыг уриалж холбогдох хууль журам, батлагдсан стандартаа даган мөрдөж ажиллах нь аливаа ёс зүйн эрсдэл, зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлэх талаар соён гэгээрүүлэх сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг үе шаттайгаар зохион байгуулсан.

Ёс зүйн дэд хорооноос санаачлан Улаанбатар хотод Хувь хүний хөгжлийн мэргэжлийн сургагч багш А.Амаржаргал багштай хамтран “Багаар ажиллах ур чадвар” сургалтыг зохион байгуулсан.

“Дэлхийн ёс зүйн өдөр” өглөө бүр бие биедээ талархал илэрхийлж, өдөр бүр хамт олондоо эерэг өдрийг бэлэглэн эерэг хандлагатай, бие биедээ тэвчээртэй, хүлээцтэй, хүндэтгэлтэй хандаж эерэг хандлагыг өөрсдийн үг, үйлдлээрээ хамт олондоо түгээцгээж ТАЛАРХЛЫН БУЛАН, кофетой яриа, АХА тэмцээн зохион байгууллаа.

Аймгийн ХХҮГ-ын мэргэжилтэнтэй хамтран сумын төр, төсвийн байгууллагын албан хаагч нарт **"ХАРИЛЦААН ДАХЬ БИДНИЙ ЯЛГАА"** сэдвээр сургалт зохион байгуулсан. Сургалтаар хувь хүний зан байдал, хамт олны уур амьсгал сайжруулах,




хувь хүний темпраментийг тодорхойлох зэрэг сонирхолтой, үр дүнтэй сургалт боллоо. Төр төсвийн байгууллагын 22 албан хаагч хамрагдлаа. Монгол улсын Ёс зүйн хорооноос зохион байгуулж буй "ХҮНДЭЛЬЕ-ЭНЭРЬЕ" ёс зүйн нөлөөллийн аянд нэгдэн удирдамж боловсруулан ажилласан.



Сүхбаатар сум:

Сүхбаатар сумын Засаг даргын Тамгын газрын ёс зүйн дэд хороо нь 4 чиглэлээр 24 төрлийн арга хэмжээг төлөвлөн 13 удаа хуралдаан зохион байгуулж, 1 гомдол мэдээлэл хүлээн авч хуулийн дагуу шийдвэрлэн ажилласан.

Ёс зүйн дэд хороо нь байгууллагын албан хаагчдыг соён гэгээрүүлэх, мэндлэх, мэндчилэх, хүндлэх соёлыг түгээх, харилцаа хандлагыг сайжруулах, эвсэг уур амьсгалыг бүрдүүлэх зорилгоор "Зөв мэндчилж сурцгаая", "Ёс зүйтэй кофе", "Талархал уучлал"-ын аяныг зарлаж нийт 107 захидал ирснийг дамжуулж өгсөн.








Аяны төгсгөлд Хамгийн олон захидал авсан албан хаагч, Хамгийн эерэг хүн, Хамгийн сайн ёс зүйтэй албан хаагчдыг шалгаруулж, дурсгалын зүйлээр шагнаж урамшуулсан.

Мэдээллийн нээлттэй ил тод байдлыг хангах зорилгоор **"Ёс зүйн дэд хорооны самбар"** гаргах ажлыг зохион байгуулан, самбарт ёс зүйн дэд хорооны гишүүдийн төлөвлөгөө, танилцуулга, уриа, ёс зүйн дүрэм, мэдээ мэдээллийг байршуулсан. Мөн нийт албан хаагчдад санал хүсэлтээ илэрхийлэх боломжоор ханган ажиллах үүднээс санал хүсэлтийн хайрцаг байршуулсан.

Монгол үндэсний бичиг, соёл, түүх, уламжлалаа хойч үедээ өвлүүлэх, монгол үндэсний хэл бичгээ сурч эзэмших, сурталчлан дэлгэрүүлэх зорилгоор "Монгол бичгийн хичээнгүй бичигтэн шалгаруулах" уралдааныг 23 албан хаагчдын дунд зохион байгуулж, эхний 3 байрыг шалгаруулан шагнаж урамшуулсан.

Эерэг сэтгэлгээний хүч ТББ-ын тэргүүн М.Эрдэнэбаттай хамтран **“Эерэг хандлага-зөв харилцаа”** сэдвийн амьдралын хэмнэл, темпрамент тодорхойлох,





дасгал ажил анхаарал төвлөрөл зэрэг сэдвээр сургалтыг зохион байгуулж, 39 албан хаагчийг хамруулсан.

Орхонтуул сум: Төрийн албан хаагчдын харилцааны, ярианы чадвар, хандлагыг сайжруулах сургалтыг зохион байгуулж, ёс зүйн дэд хорооноос **“АЖЛЫН ЦАГАА БАРИМТЛАГЧ ТАНД БАЯРЛАЛАА”** арга хэмжээг зохион байгуулж Төрийн





албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ёс зүйн зөрчил дутагдалгүй ажиллах уриалга гарган ажиллалаа.

Сумын Засаг даргын Тамгын газраас Монголын үг урлаачдын нийгэмлэгтэй гэрээ байгуулан тус байгууллагын хүмүүнлэгийн лектор Г.Бандицэрэн /chila lector/ **“Эерэг”** сэдэлжүүлэх лекцийг төрийн албан хаагч, сурагчид, сумын иргэд нийт 410, “Ёс зүйн академи”-н багш Ж.Оймандахын **“Хувь хүний ёс зүйн төлөвшил”,** “Байгууллагын соёл” сэдэвт сургалтад 11 байгууллагын 109 төрийн албан хаагчийг хамруулсан.

Байгууллагын сайн соёлыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор ёс зүйн дэд хорооноос ажлын цаг баримтлан, ажилдаа эртлэн ирсэн албан хаагчдад “АЖЛЫН ЦАГАА БАРИМТЛАГЧ” танд баярлалаа арга хэмжээг зохион байгуулсан.

Урлагийн сэтгэл засал судлалын төвөөс сургагч багш нарыг “ Баг хамт олны уур амьсгалыг эерэгжүүлэх, стресс менежмент” сэдвээр сургалт зохион байгуулж 16 ажилтан, албан хаагч хамрагдсан.

Түшиг сум:

Ёс зүйн дэд хороог Засаг даргын тамгын газрын даргын 2024 оны 5-р сарын 28 -ны өдрийн А/14 тоот тушаалаар шинэчлэн, 3 албан хаагчийн бүрэлдэхүүнтэйгээр

үйл ажиллагаа явуулж байна. Сумын Засаг даргын Тамгын газрын ёс зүйн дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд нийт 7 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгагдсан.

Ёс зүйн дэд хороо нь 2025 онд 6 удаа хуралдаж, дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх зорилгоор албан хаагчдад зориулан явуулах сургалт, мэдээлэл, албан хаагчдаас авах санал асуулга, дүн шинжилгээг боловсруулах, дүгнэлт, зөвлөмж гаргах, ирсэн өргөдөл гомдлыг шийдвэрлэх зэрэг асуудлаар хэлэлцэж шийдвэрлэн ажилласан.



Нөлөөллийн ажлын хүрээнд 5 ажил арга хэмжээ зохион байгуулан давхардсан тоогоор 440 албан хаагч, ард иргэд, хүүхдүүд хамрагдсан байна.



“Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулга”, “Ёс зүйн дүрэм” сэдэвт сургалтыг зохион байгуулж, 24 албан хаагчийг, Төрийн албаны шинэтгэл–Сэлэнгэ аймагт аянд нэгдэн сумын төр төсвийн байгууллагуудын албан хаагчдад **“ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙГ ЭРХЭМЛЭЖ ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ИРГЭН БҮРТ ХҮРГЭЭ”** сэдэвт сургалтыг 5 байгууллагын 46 албан хаагчдыг тус тус хамруулсан.

Ёс зүйн дэд хороо нь сумын төрийн албан хаагчдын нэгдсэн зөвлөгөөнийг хамтран зохион байгуулсан.



Байгууллагын ёс зүйн дэд хороо нь **“Хүндлэе энэрье”** аянд нэгдэж 6 арга хэмжээг төлөвлөн байгууллагын албан хаагчдад ёс зүйн эерэг хандлага, төлөвшүүлэх соён гэгээрүүлэх үйл ажиллагааг идэвхжүүлэн ажиллалаа. Аяны хүрээнд өвлийн дархлаа дэмжих өглөөний халуун аарц, халуун хайлмагаар албан хаагчдын дархлааг дэмжиж мөн байгууллагын ёс зүйн хорооны самбарын мэдээллийг шинэчлэн өрөө тасалгааны хананд “Хүндлэе энэрье” аяны хэвлэмэл хуудас байршуулан эерэг орчин бүрдүүлээд байна. Мөн **“Хайр түгээе”** арга хэмжээ зохион байгуулан байгууллагын 30, албан хаагчдын 57 хүүхдэд 3 багцын витамин, 128 малчин өрхийн малчид болон малчдын хүүхдүүдэд 300 ш витамин нийт 237 хүнд 3,299.0 мянган төгрөгний витаминжуулалт хийсэн.

Хүдэр сум

Хүдэр сумын Засаг даргын Тамгын газрын Ёс зүйн дэд хороо 2025 оны байдлаар 3 цогц сургалтыг зохион байгуулж давхардсан тоогоор 239 албан хаагчийг хамруулсан.

Төрийн байгууллага, төрийн албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх зорилгоор **“Манай байгууллагын нэг өдөр”, “Миний ажлын нэг өдөр”** арга хэмжээ, ажил мэргэжлийн болон баримт бичгийг боловсруулах ур чадварын уралдаан, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийг сурталчлах зорилгоор “ЕСӨН НҮД” тэмцээнийг явуулж, байгууллагын 25 албан хаагчийг хамруулсан. Мөн ёс зүйн дэд хорооноос сумын төр төсвийн байгууллагын албан хаагчдад Төрийн албаны тухай, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай, Зөрчлийн тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулиар, мөн “Зүрх сэтгэл ба харилцаа хандлага” сэдвээр сургагч багш Шинэбаяртай хамтран сургалт сурталчилгааны ажлыг 85 албан хаагчдад зохион байгуулсан. **Дархан-Уул аймгийн сэтгэц наркологийн төв, сумын ёс зүйн дэд хороотой хамтран**“ мансуурах эмгэг, хорт зуршил”, “Эерэг хандлага сэтгэл зүйг удирдах”, “Байгууллагын соёл, ажилчдын хандлага”, “Стресс менежмент” сургалтуудыг зохион байгуулж 154 албан хаагч цогц сургалтад хамрагдсан.







ДҮГНЭЛТ.

Төрийн албан хаагчийн ёс зүй, тэднийг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, иргэд, олон нийтийн төрд итгэх итгэлийг нэмэгдүүлэхэд төрийн байгууллага дахь Ёс зүйн дэд хороод анхаарах,

ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ САНАЛ:

1.Ёс зүйн хорооны 2024 оны “Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” 10 дугаар тогтоолын 4-д заасан гомдол мэдээлэл шалган шийдвэрлэх харьяалалд Сумын Тамгын газрын дарга, томилох эрх бүхий албан тушаалтан, ёс зүйн дэд хорооны дарга, гишүүдийн ёс зүйн асуудлаар ирсэн гомдол мэдээллийг аймгийн Засаг даргын Тамгын газрын ёс зүйн дэд хороо шалгахаар байгааг өөрчлөн аймгийн Засаг даргын дэргэдэх ёс зүйн хороог удирдлагын багаас сонгон байгуулж шалган шийдвэрлэдэг болох,

2.Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 13.4.1.гишүүнээр ажилласны төлөө урамшуулал авах, Ёс зүйн дэд хорооны ажиллах журмын 3.8 5 болон 7 хүний бүрэлдэхүүнтэй Дэд хорооны нарийн бичгийн даргад хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 50 хувьтай тэнцэх хэмжээний урамшууллыг сар бүр, дарга, гишүүдэд хурал болон бусад арга хэмжээнд оролцсон ирц, идэвх оролцоог харгалзан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцож, улиралд нэг удаа урамшуулал олгоно. 3 хүний бүрэлдэхүүнтэй Дэд хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүнд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэх хэмжээний урамшууллыг улирал

тутамд олгоно гэсэн заалт орон нутагт хэрэгжихгүй байгаад анхаарах, шийдвэрлүүлэх шаардлагатай байна.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ЁС ЗҮЙН ДЭД ХОРОО